

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2012 ОНЫ ЭХНИЙ 08 САРЫН БАЙДЛААР)

I. ТӨСӨВ:

Төсвийн орлого

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2012 оны эхний 8 сард аймгийн төсөвт 6548.0 сая төгрөгийн орлого орохоос 7303.0 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 11.5 хувиар буюу 754.9 сая төгрөгөөр давуулан биелүүлэв.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 2095.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2926.3 сая төгрөгийн орлогыг оруулж, төлөвлөгөөг 830.4 сая төгрөгөөр буюу 39.6 хувиар давуулан биелүүллээ. Төсвийн орлогын бүрдүүлэлтийг Өлзийт, Бүрд сумдаас бусад сумдад 105.5-190.4 хувиар биелүүлжээ.

Аймгийн төсвийн орлогын 71.4 хувийг тусламжийн орлогоор, 17.0 хувийг орлогын албан татвараар, 0.7 хувийг өмчийн татвараар, 3.3 хувийг тусгай зориулалтын орлогоор, 5.6 хувийг бусад албан татвараар, 1.5 хувийг татварын бус орлогоор, 0.5 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.


Улсын төвлөрсөн төсөвт аж ахуйн нэгжийн орлогын татвараар 220.5 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 501.0 сая төгрөг, онцгой татвараар 72.6 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 35.9 сая төгрөг, бүгд 830.0 сая төгрөгийг шилжүүлжээ.



Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 35378.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 47.5 хувиар буюу 11400.0 сая төгрөгөөр илүү байна.

Улсын болон орон нутгийн нийт төсвийн зардлын 18.1 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 3.5 хувийг нийгмийн хэв журам аюулгүй байдалд, 52.5 хувийг боловсролын салбарт 19.4 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.6 хувийг нийгмийн хангамж, халамжийн салбарт, 0.4 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 5.5 хувийг эдийн засгийн бусад салбарт зарцууллаа.



Өглөг,авлага

Эхний 8 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагууд 67.6 сая төгрөгийн өртэй байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 58.7 хувиар буурч, улсын төсвийн байгууллагууд 523.1 сая төгрөгийн өртэй байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 47.4 хувиар өссөн байна.

Өглөгийн 33.3 хувийг түлш халаалтын зардал, 11.4 хувийг тээврийн зардал, 12.2 хувийг цалин, 1.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 21.6 хувийг эмийн зардал, 4.1 хувийг хоолны зардал, 0.7 хувийг гэрэл цахилгааны зардал, 15.1 хувийг бусад зардал тус тус эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс түлш халаалтын зардал 12.7 пунктээр, эмийн зардал 11.2 пунктээр өсч, тээврийн зардал 7.8 пунктээр, цалингийн зардал 6.0 пунктээр, гэрэл цахилгааны зардал 3.6 пунктээр, бусад зардал 6.3 пунктээр, НДШ-ийн зардал 3.3 пунктээр буурсан байна.Тухайн сард шинээр үүссэн өглөг 106.5 сая төгрөг буюу нийт өглөгийн 18.0 хувийг эзэлж байна.Нийт өглөгийн 103.9 сая төгрөг буюу 17.6 хувь нь тухайн сард төлөгдсөн байна.

II. АРИЛЖААНЫ БАНК.

Манай аймагт 2012 онд арилжааны 6 банкны салбар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.

Арилжааны банкны салбаруудаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 8 сард 76330.7 сая төгрөг болж, 56.1 хувь нь ХААН банк, 18.0 хувь нь Хадгаламж банк, 20.6 хувь нь Хас банк, 1.9 хувь нь Төрийн банк, 0.4 хувь нь Капитал банк-д ногдож байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 52.2 хувийг 2012 оны эхний 8 сард олгосон зээл эзэлж байна. Нийт зээлийн 0.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 25965.1 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

Байгууллага, иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 36134.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнээс 6303.4 сая төгрөг буюу 21.1 хувиар өссөн байна.

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ:

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 20256.6 сая төгрөг, зарлага 18467.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 6915.5 сая төгрөг буюу 51.8 хувиар, зарлага 5985.0 сая төгрөг буюу 47.9 хувиар тус тус өссөн байна.Нийгмийн даатгалын сайн дурын орлого 548.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 310.4 сая төгрөг буюу 2.3 дахин, эрүүл мэндийн сангийн орлого 105.5 сая төгрөг буюу 7.8 хувиар өсчээ. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 16206.3 сая төгрөг болсны 80.4 хувийг өндөр настны, 12.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.7 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 0.1 пунктээр буурч, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 0.2 пунктээр өссөн байна.

Аймгийн хэмжээнд 12304 хүнд тэтгэвэр олгосны дотор өндөр насны тэтгэврийг 9412 хүнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 1936 хүнд, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 956 хүнд тус тус олгожээ.

Эхний 8 сард 1397 хүнд 479.5 сая. төгрөгийн тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс тэтгэмж авагчдын тоо 113 хүнээр буюу 8.8 хувиар,олгосон тэтгэмжийн хэмжээ 136.1 сая төгрөг буюу 39.6 хувиар өссөн байна.

Эмнэлэгийн санхүүжилтэд 1742.6 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 479.4 сая төгрөг буюу 49.8 хувиар, ажилгүйдлийн тэтгэмж 5.1 сая төгрөг буюу 15.0 хувиар тус тус өсчээ.


Нийгмийн халамж:

Эхний 8 сард нийгмийн халамжийн сангаас 26429 хүнд 4675.6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 2813 хүнээр буюу 11.9 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 1183.2 сая.төгрөг буюу 33.9 хувиар өссөн байна.Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын 13.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 9.2 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 3.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 4.5 хувь нь ахмад настанг асарч буй иргэд, 36.9 хувь нь алдарт эхийн одонтой эхчүүд байна.Нийгмийн халамжийн сангаас 4675.6 сая.төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосны 1480.2 сая.төгрөг буюу 31.6 хувийг халамжийн тэтгэвэрт, 734.3 сая төгрөг буюу 15.7 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 1365.9 сая төгрөг буюу 29.2 хувийг алдарт эхийн одонтой эхчүүдэд, 339.6 сая төгрөг буюу 7.3 хувийг ахмад настанг асарч буй иргэдэд, 256.8 сая төгрөг буюу 5.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд тус тус олгожээ.

IV.ХӨДӨӨ АЖ АХУЙ:


Аймгийн хэмжээгээр 2012 оны эхэнд төллөх насны нийт 968.9 мянган эх мал тоологдсон. 2012 оны эхний 8 сарын байдлаар 881.5 мянган мал буюу оны эхэн тоологдсон нийт эх малын 91.0 хувь нь төллөсөн байна. Ингэний 53.7 хувь, гүүний 73.2 хувь, үнээний 76.3 хувь, эм хонины 92.7 хувь, эм ямааны 92.6 хувь нь төллөжээ. Баян-өндөр, Бат-Өлзий, Нарийнтээл, Уянга, Хужиртаас бусад сумдуудад 90-ээс дээш хувьтай төллөсөн байна. Мал төлөлтийн хувь өмнөх оны мөн үеээс 6.4 пунктээр өндөр байна.

Мал төлөлтийн хувь, 2012 оны эхний 8 сарын байдлаар




Гарсан төлийн 99.4 хувь буюу 880.6 мянган төл бойжиж байна. Өмнөх оны мөн үед төл бойжилтын хувь 97.6 хувь байсан байна. Төл бойжилтын хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал ботго 98.8 хувь бойжсон нь өмнөх оны түвшинд, бусад төрөл дээр төл бойжилт 1.0-2.0 пунктээр өндөр байна. Төл бойжилт Баян-өндөр, Бүрд, Баянгол, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Сант, Төгрөг сумдуудад 100.0 хувь, бусад сумдуудад 96.9-99.8 хувьтай байна.

Төл бойжилтын хувь, 2012 оны эхний 8 сарын байдлаар




Аймгийн хэмжээгээр 2012 оны эхний 8 сарын байдлаар 14 тэмээ, 317 адуу, 1260 үхэр, 2208 хонь, 2897 ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.3 хувьтай тэнцэх 6696 том мал зүй бусаар хорогдоод байна. Нийт хорогдсон том малын оны эхний малд эзлэх хувь нь урд оны мөн үеээс 0.7 пунктээр буурсан байна.

Зүй бусаар хорогдсон том мал, 2012 оны эхний 8 сарын байдлаар



Нийт хорогдсон малын 0.2 хувийг тэмээ, 4.7 хувийг адуу, 18.8 хувийг үхэр, 33.0 хувийг хонь, 43.3 хувийг ямаа эзэлж байна.


Зүй бусаар хорогдсон том малын бүтэц, төрлөөр



2012 оны эхний 8 сарын байдлаар Баян-өндөр суманд 43 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.02 хувь, Бат-Өлзий суманд 475 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.43 хувь, Баруунбаян-улаан суманд 253 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.21 хувь, Баянгол суманд 38 толгой мал буюу 0.03, Есөнзүйл суманд 18 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.02 хувь, Зүүнбаян-Улаан суманд 48 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.06 хувь, Богд суманд 384

толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.18 хувь, Нарийн тээл суманд 1090 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.71 хувь, Тарагт суманд 1024 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.24 хувь, Төгрөг суманд 8 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.001 хувь, Уянга суманд 2528 толгой мал буюу 1.6 хувь, Хайрхандулаан суманд 91 толгой мал буюу оны эхэндтоологдсон малын 0.06 хувь, Хужирт суманд 150 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.12 хувь, Хархорин суманд 309 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.19 хувь, Арвайхээр суманд 237 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь тус тус хорогдсон байна. Бүрд, Гучин-Ус, Өлзийт, Сант сумдуудад том малын хорогдол гараагүй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо, сумаар



Аймгийн хэмжээнд 2012 оны эхний 8 сард өвчнөөр 167 том мал хорогдсон нь нийт хорогдсон том малын 5.2 хувийг эзэлж байна. Өвчнөөо хорогдсон том малын 5 нь адуу, 2 нь үхэр, 98 нь хонь, 62 нь ямаа байна. Эдгээр нь Бат-Өлзий суманд 80 хонь, 49 ямаа, Есөнзүйл суманд 3 адуу, 10 хонь, 5 ямаа, Арвайхээр суманд 2 адуу, 2 үхэр, 8 хонь, 8 ямаа хорогдоод байна.

Хээлтэгчийн хорогдол эхний 8 сарын байдлаар 1605 толгой байгаа ба оны эхний хээлтэгчийн 0.2 хувь нь хорогдоод байна. Энэ нь нийт хорогдсон том малын 23.9 хувийг эзэлж байна. Баян-Өндөр суманд 15, Бат-Өлзий суманд 96, Баруунбаян-улаан суманд 83, Баянгол суманд 24, Богд суманд 262, Нарийнтээл суманд 138, Тарагт суманд 473, Уянга суманд 413, Хайрхандулаан суманд 12, Хужирт суманд 18, Хархорин суманд 20, Арвайхээр суманд 51 толгой эх мал тус тус хорогдсон байна.

Хээлтэгчийн хорогдлыг 5 төрөл дээр нь харвал 5 ингэ, 73 гүү, 86 үнээ, 602 эм хонь, 839 эм ямаа зүй бусаар хорогдоод байна.


Аймгийн хэмжээнд 3406.5 га-д үр тариа, 327.3 га-д төмс, 159.5 га-д хүнсний ногоо тариалсан ба 8 сарын 30-ны байдлаар 17 га-аас 207 тн төмс, 13.7 га-аас 163 тн хүнсний ногоо хураагаад байна. Үр тариа, малын тэжээл хураалт одоогоор эхлээгүй байна. Байгалийн хадлан 1405 тн, гар тэжээл 253 тн бэлтгээд байгаа нь урд оны мөн үетэй харьцуулахад тус бүр 4 дахин бага байна.

V. АЖ ҮЙЛДВЭР:

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 8 сард 5609.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5200.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 45.0 хувиар, борлуулалтын орлого 49.3 хувиар өссөн байна.

Энэхүү өсөлтөд нүүрс олборлолт, цэвэр ус, талх, нарийн боов, хэрчсэн гурил, гутал, оёдол зэрэг үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.5 хувиас 3.1 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Нүдний шилний үйлдвэрлэл 41.4 хувиар буурсан байна. Үйлдвэрлэл явуулсан цэг салбарыг мэдээнд нэмж хамруулсан нь аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний өсөлтөд зохих хэмжээгээр нөлөөллөө.

Хүнсний зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 511.9 сая төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 3511.5 сая төгрөг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 1212.6 сая төгрөгт хүрч, нийт борлуулалтад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 9.8 хувь болж 0.5 пунктээр буурч, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 67.1 хувь болж 4.7 пунктээр буурч, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 23.2 хувь болж 5.3 пунктээр өслөө.

Борлуулсан бүтээгдэхүүн салбарын бүтцээр




VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА:

Тээвэр

Авто замын тээврээр 2012 оны эхний 8 сард давхардсан тоогоор 118.6 мянган зорчигч зорчиж, 15.2 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 19.7 мян. хүн буюу 19.9 хувь, тээсэн ачаа 1.7 мян.тн буюу 12.6 хувиар өсчээ.

Зорчигч эргэлт, тээсэн ачаа



Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр авто замын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 8 сард 998.2 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 131.6 сая төгрөг буюу 15.2 хувиар өсчээ.

Холбоо

Холбооны тарифын орлого өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 22.7 хувиар өсч 203.3 сая төгрөг болсоны дотор хүн амаас орсон орлого 1.7 дахин өсч 90.9 сая төгрөгт хүрсэн байна. Телефон цэгийн тоо 1034 байгаа нь урьд оны мөн үеийнхээс 76-аар буурсан байна.

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ:

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлгийн 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж түүний үндсэн дээр инфляцыг тооцдог.

2012 оны 8 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарыхаас 0.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.2 хувиар, 2011 оны 12 дугаар сарынхаас 5.0 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 14.1 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 7 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 213 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 16.4 хувийх нь үнэ өсч, 9.5 хувийх нь үнэ буурч, 74.1 хувийх нь үнэ тогтвортой байлаа.

Энэ сард өмнөх сарынхаас шар будаа 5.9 хувиар, ургамлын тос 0.6 хувиар, манжингийн үнэ 2.6 хувь, зөөлөн чихрийн үнэ 1.8 хувь, компот 5.3 хувиар, үзэм 4.0 хувиар, тахианы гуя 7.1 хувиар, байцаа 25.0 хувиар, сонгино 11.1 хувиар, улаан лооль 7.1 хувиар, жимсний чанамал 25.0 хувиар, ноосон цамц 14.5 хувиар, эрээн даавуу 7.8 хувиар өсч, хонины махны үнэ 8.6 хувиар, үхрийн ястай махны үнэ 3.8 хувиар, адууны махны үнэ 7.9 хувиар, ямааны махны үнэ 6.9 хувиар, даралтны эмний үнэ 7.9 хувиар, хорхой ааруулны үнэ 2.9 хувиар тус тус буурсан байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 78.8 хувийх нь буюу 168 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 10.3 хувийх нь буюу 22 нэрийн барааны үнэ буурч, 10.9 хувийх нь үнэ тогтвортой байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс өөхөн тос сүү, элсэн чихэр, тараг, аарц, гурил, будаа, зэргийн үнэ 0.6-22.3 хувиар буурсан боловч бүх төрлийн малын мах, дээлийн даавуу, торго, дотуур, гадуур хувцас, гутал, гэр ахуйн хэрэгсэл, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, зэрэг бараа, үйлчилгээний үнэ 1.2-65.3 хувиар нэмэгдсэн байна.

VIII. НИЙТ БАРАА ГҮЙЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд 2012 оны эхний 8 сард 23789.7 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4739.5 сая төгрөг буюу 24.9 хувиар өссөн

байна.Аж ахуй нэгж иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 33 цэгээр буюу 2.7 хувиар өсчээ.

Бараа гүйлгээний орлого өмнөх оны мөн үеийнхээс 24.9 хувиар өсөхөд барааны дэлгүүрийнх 75.2 хувиар, хүнсний дэлгүүрийнх 56.2 хувиар, авто сэлбэгийнх 50.2 хувиар, цайны газрынх 65.0 хувиар, авто засварын газрынх 47.6 хувиар, шатахуун борлуулалтынх 8.9 эм борлуулалтынх 15.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Бараа гүйлгээний орлогын 4.5 хувийг барааны дэлгүүр 25.5 хувийг хүнсний дэлгүүр, 3.0 хувийг авто сэлбэгийн дэлгүүр, 1.2 хувийг барилгын материалын дэлгүүр, 2.4 хувийг ресторан бар, 1.8 хувийг цайны газар, 0.2 хувийг түц 3.5 хувийг контейнер, 2.4 хувийг авто засварын газар, 52.0 хувийг шатахуун борлуулалт, 3.5 хувийг эм борлуулалтын орлого эзэлж байна.

IX.АЖИЛГҮЙЧҮҮД:

Аймгийн ХХҮХ-т бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2240 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1644 хүнээр буюу 42.3 хувиар буурчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1646 буюу 73.5 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Эхний 8 сард ажилгүй 158 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй иргэдээс 115 иргэн ажилд зуучлагдан оржээ. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 57 хүнээр буюу 56.4 хувиар өсчээ.

Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо 8 сард 115 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.3 дахин өссөн байна.Ажилд орсон иргэдийн 18.3 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 81.7 хувь нь нөхөрлөл компанид оржээ.

Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд зуучлагдан орсон хүний тоо



X.АЖЛЫН ШИНЭ БАЙР:

Аймгийн хэмжээнд эхний 8 сарын байдлаар 1062 ажлын байр шинээр бий болж өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар буурчээ. Үүний 41.1 хувь буюу 437 нь эмэгтэйчүүд байна.

Ажлын байрны 44.2 хувь нь ХАА-н салбарт, 16.6 хувь нь боловсруулах үйлдвэрт, 12.8 хувь нь барилгын салбарт, 9.9 хувь нь худалдааны салбарт, 1.4 хувь нь төрийн байгууллагад, 1.2 хувь нь банк санхүүгийн байгууллагад, 13.9 хувь нь бусад салбарт бий болжээ.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн насны хувьд 154 буюу 14.5 хувь нь 15-24, 341 буюу 32.1 хувь нь 25-34, 327 буюу 30.8 хувь нь 35-44, 230 буюу 21.6 хувь нь 45-59, 10 буюу 1.0 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна.

Аймгийн хэмжээнд эхний 8 сард бий болсон ажлын шинэ байрны 19.7 хувь нь Арвайхээр суманд, 13.9 хувь нь Уянга суманд, 6.6 хувь нь Хайрхандулаан, Хужирт сумдад, 3.8 хувь нь Баян-Өндөр суманд, 6.0 хувь нь Бат-Өлзий суманд, 6.7 хувь нь

Баянгол суманд, 9.5 хувь нь Нарийнтээл суманд, 5.5 хувь нь Тарагт суманд, 4.6 хувь нь Гучин-ус суманд, 17.1 хувь нь бусад сумдад бий болжээ.

XI.ЭРҮҮЛ МЭНД:

Аймгийн хэмжээнд эхний 8 сард 1688 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 25 эхээр буюу 1.5 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 1696 болж, 36 хүүхэд буюу 2.2 хувиар өссөн байна.

Нэг хүртэлх насандаа 40 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 4 хүүхдээр буюу 9.1 хувиар буурсан байна.

Халдварт өвчнөөр эхний 8 сард 676 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 258 хүнээр буюу 27.6 хувиар буурсаны дотор тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 52 хүн буюу 52.0 хувиар, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 171 хүнээр буюу 6.7 дахин, заг хүйтнээр өвчлөгчдийн тоо 51 хүнээр буюу 5.2 дахин, вируст гепатитаар өвчлөгчдийн тоо 233 хүнээр буюу 50.8 хувиар, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 5 хүнээр буюу 8.9 хувиар тус тус буурч, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 200 болж бүртгэгдсэн байна. Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс Бат-Өлзий суманд 6 хүнээр буюу 50.0 хувиар, ББ-Улаан суманд 3 хүнээр буюу 2.0 дахин, Богд суманд 10 хүн буюу 30.3 хувиар, Тарагт суманд 10 хүн буюу 52.6 хувиар, Хайрхандулаан суманд 5 хүн буюу 33.3 хувиар, Хархорин суманд 12 хүн буюу 80.0 хувиар, Бүрд суманд 3 хүн буюу 4.0 дахин өсчээ. Харин Гучин ус суманд 45 хүнээр буюу 7.4 дахин, ЗБУлаан, Есөнзүйл сумдад 11 хүнээр буюу 2.8 дахин, Сант суманд 8 хүнээр буюу 40.0 хувиар, Төгрөг суманд 27 хүнээр буюу 7.7 дахин, Арвайхээр суманд 108 хүнээр буюу 24.0 хувиар буурчээ. Уянга суманд гахайн хавдраар 50 хүн, Арвайхээр суманд 116 хүн, Тарагт суманд 4 хүн, Хархорин суманд 10 хүн, Хайрхандулаан суманд 2 хүн, Хужирт суманд 2 хүн, Сант суманд 7 хүн, Нарийнтээл, Баянгол суманд 3 хүн, Баян-Өндөр суманд 2 хүн, Нарийнтээл суманд 1 хүн, Өлзийт суманд 3 хүн, өвчилж шинээр бүртгэгдсэн байна.

XII.ГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд эхний 8 сард 369 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 66 гэмт хэргээр буюу 21.8 хувиар өссөн байна. Үүнд өмнөх оны мөн үеийнхээс хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.6 хувиар, иргэний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 54.5 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 64.8 хувь нь сумдад, 35.2 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 8 гэмт хэргээр буюу 38.1 хувиар буурчээ. Хулгайлах гэмт хэргийн 60.0 хувийг иргэдийн орон байрны хулгай, 29.2 хувийг малын хулгай, 10.8 хувийг авто тээврийн хэрэгслийн хулгай тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс Тарагт суманд 41.7 хувиар, Хужирт суманд 33.3 хувиар, Сант суманд 50.0 хувиар, Хайрхандулаан суманд 50.0 хувиар, Хархорин суманд 70.3 хувиар, Арвайхээр суманд 22.6 хувиар, Гучин-Ус суманд 75.0 хувиар, Богд суманд 33.3 хувиар, Баян-өндөр суманд 40.0 хувиар, Бүрд суманд 62.5 хувиар, ББ-Улаан суманд 33.3 хувиар, Бат-Өлзий суманд 21.7 хувиар нэмэгдэж, Баянгол суманд 25.0 хувиар, Өлзийт суманд 60.0 хувиар, Төгрөг суманд 14.3 хувиар, Уянга суманд 27.6 хувиар, ЗБ-Улаан суманд 16.7 хувиар буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон 363 сэжигтэн, яллагдагчийн 226 хүн буюу 62.2 хувь нь 18-35 хүртэл насных, 112 хүн буюу 30.8 хувь нь 35-аас дээш насных, 25 хүн буюу 6.9 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 4.4

хувь нь сурагчид, 8.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 34.7 хувь нь малчид, 36.6 хувь нь ажилгүй иргэд байна.

Түр саатуулсан тээврийн хэрэгсэл 3143 болж өмнөх оны мөн үеийнхээс 677 тээврийн хэрэгслээр буюу 27.4 хувиар, авто машин жолоодох эрхээ хасуулсан жолооч 145 хүнээр буюу 85.8 хувиар өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 8.9 хувь нь гудамж талбайд, 2.2 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд, 33.1 хувь нь согтуугаар, 14.1 хувь нь бүлэглэн үйлдсэн хэргүүд эзэлж байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 13.8 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25.8 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 2.0 хувиар өсчээ.

Гэмт хэргийн улмаас 383.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 188.9 сая төгрөг буюу 97.3 хувиар өсчээ. Нийт хохирлын 67.6 хувь буюу 258.8 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас 90 хүн нас баржээ. Үүний 10.0 хувь нь бусдын гарт амь үрэгдсэн, 17.8 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 72.2 хувь нь золгүй учирлаар нас барсан байна. Эмэгтэйчүүд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 80.0 хувиар өсчээ.

Аймгийн хэмжээнд эхний 8 сард 948 хүн эрүүлжүүлэгдэж, 278 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 313 буюу 24.8 хувиар буурч, баривчлагдсан хүний тоо 77 буюу 38.3 хувиар өссөн байна.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
MAIN INDICATORS

9/6/2012

Үзүүлэлтүүд	/Indicators/	Хэмжих нэгж /Unit/	2010	2011	2012	2012/2011%
Төсвийн орлого	/budget revenue/	сая.төг mln.tog	2202.3	3238.6	2926.3	90.4
Төсвийн зарлага	/Budget expenditure/	сая.төг mln.tog	19420.9	23978.2	35378.3	147.5
Зээлийн өрийн үлдэгдэл	/Remainder of loan debts/	сая.төг mln.tog	32857.6	56323.3	76330.7	135.5
Үүнээс: хугацаа хэтэрсэн	/whom: outstanding debts/	сая.төг mln.tog	499.7	217.2	257.5	118.6
Хадгаламж	/Deposits/	сая.төг mln.tog	19034.1	29830.6	36134	121.1
Төллөсөн хээлтэгч	/Breeding stock/	мян.тол /thous.heads/	541.2	807.5	881.4	109.2
Бойжсон төл	/rearing of young animals/	мян.тол /thous.heads/	292.3	767.9	880.6	114.7
Том малын зүй бус хорогдол	/Losses of adult animals/	мян.тол /thous.heads/	1643.6	20.5	6.7	32.7
Ургац хураалт /total crops / :						
Үр тариа /Cereals/		тн /tn/				#DIV/0!
Төмс/Potatoes/		тн /tn/	293.0	35.7	207	579.8
Хүнсний ногоо/Vegetable/		тн /tn/	198.5	12.5	163	1304.0
Байгалийн хадлан /gross hay harvest/		тн /tn/	14728.4	5947.0	1405	23.6
Гар тэжээл / hand made fodder/		тн /tn/	1791.5	997.3	253	25.4
Аж үйлдвэрийн НБ	/Gross industrial output/	сая.төг mln.mog	2740.9	3869.5	5609.7	145.0
Борлуулсан бүтээгдэхүүн	/Sold production/	сая.төг mln.tog	2527.8	3507.0	5236.1	149.3
Тээсэн ачаа	/Carried freight/	мян.тн /thous.tn	12.8	13.5	15.2	112.6
Зорчигч зргэлт	/Passenger turnover/	мян.хүн.км /thouspass.km/	26898.3	30538.1	34830.4	114.1
Холбооны орлого	/Revenue of communication/	сая.төг mln.tog	158.9	165.7	203.3	122.7
Телефон цэг	/Number of telephones/	тоо/number/	1522	1110	1034	93.2
Ажилгүйчүүд /Unemployment/		хүн/people/	2680	3884	2240	57.7
Халдварт өвчнөөр өвчлөгчид	/number of infectious disease cases/	хүн/people/	678	934	676	72.4
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	/infant deaths at age of 1 years/	хүн/people/	54	44	40	90.9
Бүртгэгдсэн хэрэг/Offences/		тоо/number/	239	263	369	140.3
Хэрэгт холбогдогсод /Offenders/		хүн/people/	245	241	363	150.6

**1.ТӨСӨВ
BUDJET**

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,оны үнээр,мян.төг
STATE BUDGET REVENUE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн орлого	гүйц	2012		Budget revenue
	2011	төл	гүйц	
Татварын орлого	2964904	1983556.3	2738968.8	<i>Tax revenue</i>
Орлогын албан татвар	1583990	1432130.4	1744747.7	<i>-Individuals</i>
- Өмчийн татвар	59023.7	42174	77265.6	<i>-Property tax</i>
- Бусад татвар	572567.6	196038.7	574631.9	<i>-Other tax</i>
Татварын бус орлого	215588.5	94047.3	157823.1	<i>Non-tax revenue</i>
Хөрөнгийн орлого	58138.2	18300	29517.4	<i>Capital revenue</i>
Дүн	3238631	2095903.6	2926309.3	<i>Total</i>

Орлогын эх үүсвэр

Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	0	4166650.0	4166650.0	<i>-Corporate tax</i>
Аймагт орох татварын орлого	0	2150840.4	2558277.6	<i>-Value added tax</i>
Суманд орох татварын орлого	0	230559.8	578122.2	<i>-Excise tax</i>
Дүн	0.0	6548050.2	7303049.8	<i>Total</i>

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,оны үнээр,мян.төг
STATE BUDGET EXPENDITURE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн зарлага	гүйц	2012		Budget expenditure
	2011	төл	гүйц	
-Цалин хөлс	14141972	21922789	21395773	<i>-Wages&salaries</i>
-Нийгмийн даатгалын шимтгэл	1401087	1842780.8	1733620.7	<i>-Social security contribution</i>
-Эрүүл мэндийн даатгал	0	378516.1	371897	<i>-Health insurance</i>
-Бараа үйлчилгээний бусад зардал	7665397	8340861.8	7428622.2	<i>-Goods and services expenses</i>
Татаас ба шилжүүлэг	755279.4	3376531.2	3150657.2	<i>-Subsidie & transfers</i>
-Хөрөнгө оруулалт	14500	1504669.6	1297750	<i>-Investment</i>
НИЙТ ЗАРДАЛ	23978235	37366148.1	35378319.6	TOTAL EXPENDITURE

06-Sep-12

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

1.2 ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА сумаар, оны үнээр, мян.төг
 BUDGET REVENUE, EXPENDITURE ,by soum , at current prices , thous.tog

Сум	Орлого Revenue			Зарлага Expenditure		
	2012			2012		
	төл	гүйц	%	төл	гүйц	%
Баян-Өндөр	43158.8	50964.2	118.1	845838.0	791207.6	93.5
Бүрд	45266	44704.8	98.8	770953.4	727222.5	94.3
Бат-Өлзий	96188	135409.9	140.8	1304827.8	1180696.1	90.5
ББ-Улаан	38588	45360.1	117.5	748348.8	702426.8	93.9
Баянгол	45150.9	65355.9	144.7	883351.8	843864.3	95.5
Гучин-Ус	34043	45867.3	134.7	733716.8	713476.9	97.2
Есөнзүйл	46060	48603.2	105.5	833492.6	794859.0	95.4
Өлзийт	35136.5	34934	99.4	605788.6	575373.7	95.0
ЗБ-Улаан	39363	49795.5	126.5	719690.7	688243.0	95.6
Богд	48725	61655.9	126.5	1085402.8	989551.5	91.2
Нарийнтгээл	65143	72867	111.9	959080.9	911759.3	95.1
Сант	45330	49672.3	109.6	899061.9	860314.9	95.7
Тарагт	41031.4	46468.7	113.3	697606.1	659125.2	94.5
Төгрөг	36943.2	46551.2	126.0	868479.2	845457.0	97.3
Уянга	194568.4	370415.7	190.4	1644990.3	1555842.5	94.6
Хайрхандулаан	39624.8	46831.3	118.2	795485.5	766426.5	96.3
Хужирт	126826.2	170538.8	134.5	1505700.5	1427110.8	94.8
Хархорин	352843.3	433672.5	122.9	3076081.0	2965121.1	96.4
Арвайхээр	1026518	1247281	121.5	5594477.2	5399139.7	96.5
Сум дүн Soum total	2400507.5	3066949.2	127.8	24572373.9	23397218	95.2
Аимгийн шууд	-304603.9	-140639.9	46.2	12790774.3	11981101.2	93.7
Аймаг дүн Aimag total	2095903.6	2926309.3	139.6	37363148.2	35378319.6	94.7

06-Sep-12
 СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

ӨГЛӨГИЙН МЭДЭЭ

6/9/2012

	Нийт өглөг	Үүнээс:										
		Ажиллагсад олгох цалин	Нийгмийн даатгалын шимтгэл	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Гэрэл цахилгаан	Тулш халаалт	Тээвэр	Шуудан холбоо	Хоол	Эм	Бусад	
Эхний үлдэгдэл	588216.2	67725.1	5962.3	0	1691	208783	53550.4	616.4	31945	153322.9	64620.7	
Тухайн сард төлөгдсөн өглөг	103984.3	4200	944.9	0	795.5	13365	12986.7	30.4	12825	40423.1	18413.8	
Тухайн сард шинээр үүсэн өглөг	106556.5	8554.3	4715.5	0	3551.5	1140.7	26712.4	227.7	5018	14911	41725.4	
Эцсийн үлдэгдэл	590788.5	72079.4	9732.9	0	4447	196559	67276.1	813.7	24138	127810.9	87932.3	
өглөг үүсэн хугацаа	31-60 өдөр	366052.3	72079.4	9732.9	0	3516.8	36347	47659.4	746.7	16805	117491.9	61672.8
	61-120 өдөр	138533.9	0	0	0	930.2	90527.6	13394.6	67	2675	8319	22620.2
	121 өдрөөс дээш	86402.3	0			0	69683.9	6222.1	200	4657	2000	3639.3

БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА /мян.төг/

7/9/2012

д/д	Үзүүлэлтүүд	Indicators	ХААН банк	Хадгаламж банк	ХАС банк	Төрийн банк	Капитал банк	Голомт банк
1	Монгол банкнаас арилжааны банкуудад хийсэн зузаатгал		11385000.0	1137650.0	1255000.0	80000.0	855000.0	393160.0
2	Банкны кассын орлого		33598474.0	1048754.4	26816159.8	5768482.0	563662.8	5353569.3
3	Монгол банкинд гүйлгээнээс орсон татаас		19379070.0	337650.0	4056320.0	30000.0	270000.0	3402490.0
4	Банкны кассын зарлага		25560680.0	998572.9	26833641	5870044.0	1305367.6	2817407.3
5	Зээлийн өрийн бүх үлдэгдэл		45091747.0	13758860.8	15735319	1447445.0	297394.3	0.0
6	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл		43552.0	984.3	212449.6	566.0	0.0	0.0
7	Байгууллага, иргэдийн хувийн хадгаламж		20990214.0	7914343.9	5645090.8	292263.0	190225.9	1101885.0
8	Дүн		156048737.0	25196816.3	80553979.8	13488800.0	3481650.6	13068511.6

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын мэдээ

мян.төг

Үзүүлэлтүүд						Өссөн дүнгээр	
1	Орлого	Нийгмийн даатгалын сангуудын нийт орлого				Төлөвлөгөө	19062088.8
						Гүйцэтгэл	20256679.4
						Хувь	106.3
	Үүнээс	Төсвийн дотац			Төлөвлөгөө	13270698.6	
					Гүйцэтгэл	13270698.6	
					Хувь	100.0	
		НДШ-ийн орлого			Төлөвлөгөө	5791390.3	
					Гүйцэтгэл	6985980.8	
					Хувь	120.6	
	Үүнээс	Нийгмийн даатгалын сайн дурын орлого			Төлөвлөгөө	325750.1	
					Гүйцэтгэл	548254.7	
					Хувь	168.3	
	Үүнээс	ЭМД-ын сангийн орлого			Төлөвлөгөө	1442343.7	
					Гүйцэтгэл	1463747.3	
					Хувь	101.5	
Үүнээс	ЭМД-ын хураамж			Төлөвлөгөө	89396.0		
				Гүйцэтгэл	146035.4		
				Хувь	163.4		
2	Зарлага	Тэтгэвэр			Хүний тоо	12304	
					Олгосон нь	16206326.2	
		Үүнээс	Өндөр настны			Хүний тоо	9412
						Олгосон нь	13032872.8
			ХБИргэдийн			Хүний тоо	1936
